



**НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2021 оны 01 сарын 01 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ХЯНАЛТ,
СЭРГИЙЛЭЛТ, БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ
ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ**

Улсын онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, Монгол улсын Шадар сайд, Улсын онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын коронавируст халдварын хяналт, сэргийлэлт, бэлэн байдал, дэгдэлтийн үед ажиллах хариу арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

Зохион байгуулалт, тусламж үйлчилгээний чиглэлээр:

1. Эрүүл мэндийн байгууллага бүр коронавируст халдварын хяналт, сэргийлэлт, бэлэн байдал, дэгдэлтийн үед ажиллах хариу арга хэмжээг эрчимжүүлэх, зөрчил дутагдлыг арилгах 10 хоногийн аяныг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс зохион байгуулж, үр дүнг тооцох.
2. Эрүүл мэндийн байгууллага бүр коронавирусын халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг тусламж үйлчилгээг хэсэгчилсэн болон бүрэн хаасан цагийн байдалд тохируулан шинэчлэх.
3. Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний зураглалыг үйл ажиллагаа бүрээр гаргах, эмнэлзүй, тандалт, дэмжих үйлчилгээний багуудыг тушаалаар томилж үүрэгжүүлэх.
4. Коронавирусын халдварын үед ажиллах хүний нөөцийн судалгааг ар гэрийн байдал, эрүүл мэндийн эрсдэлт байдлыг харгалзан гаргаж, хуваарийг танилцуулан гарын үсгээр баталгаажуулах.
5. Хүний нөөцийн дутагдалтай үед нөхөж ажиллуулах, гаднаас татах эмч, мэргэжилтний судалгааг гаргаж, ажлын чиг үүргийг танилцуулан мэдээлэл өгсөн байх.
6. Коронавирусын халдвартай тэмцэх, сэргийлэх чиглэлээр гарсан тушаал шийдвэрүүдийг үйл ажиллагааны онцлогт нь тохируулан гарын авлага болгон гаргаж бүх эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан албан хаагчдад судлуулах ажлыг зохион байгуулах.
7. Коронавирусын халдварын үед цагийн байдалд тохируулан, төлөвлөгөөний дагуу авах хариу арга хэмжээний чиглэлээр нийт эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан албан хаагчдад дадлага сургуулилтыг тогтмол хуваарийн дагуу явуулж, ажил үүргийг тодорхой болгон дадлагажуулах.

8. Коронавирусын халдварын үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, эмнэлгийн ор дэлгэх төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, ажиллах хүний нөөц, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг бодитойгоор тооцон гаргаж бэлэн байдлыг хангах,

9. Эмнэлгийн эрсдэл бүхий газруудад камер байрлуулж, дотоод хяналтыг тогтмол хийж байх,

10. Эмнэлгийн бүх хэсэгт бөөгнөрөл үүсгэхгүй байх, зай барих, маск зүүх, гар халдваргүйжүүлэхонцгой дэглэм тогтоож, хэрэгжилтэд захиргааны зүгээс тогтмол хяналт тавьж ажиллах

11. Эрүүл мэндийн байгууллагын хэмжээнд ашиглаж байгаа бүх тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслийн ашиглалт, бэлэн байдал, аюулгүй ажиллагаанд шалгалт хийж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, бэлэн байдлыг хангах,

12. Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн гаргасан ашиглалтын гарын авлага болон холбогдох аюулгүй ажиллагааны зааврыг тоног төхөөрөмжид байрлуулах, ашиглалтын паспортыг тухай бүр хөтлөх, мөрдөж ажиллах

13. Хүлээн авах, яаралтай тусламжийн тасагт байрлах тусгаарлах өрөөг халдвартай, завсрын, халдваргүй бүсээр тусгаарлах боломжийг бүрдүүлэн бэлэн байдлыг бүрэн хангах,

14. Эмнэлгийн ажилчдыг хамгаалах хувцас, хэрэгслээр бүрэн хангаж, өмсөх, тайлах дарааллыг бүрэн эзэмшүүлэх талаар сургаж дадлагажуулах ажлыг өдөр бүр, тасаг нэгжүүд тодорхой цагийн хуваарийн дагуу хийж хэвших,

15. Хөтөч ажилтанд ажиллах чиг үүргийг сайтар танилцуулах, арга зүйгээр хангах, өвчлөл гарсан тохиолдолд хамгийн түрүүн авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний талаар мэдлэг, чадвар олгох

16. Түргэн тусламжийн машины тээвэрлэлт хооронд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг заавар журмын дагуу тогтмол хийж, хяналт тавьж ажиллах,

17. Коронавирусын халдвартай өвчтөнийг хугацаа алдахгүй илрүүлэх, бусад үйлчлүүлэгчтэй холихгүй, халдварыг тархаахгүй байх зорилгоор эрэмбэлэн ангилалт хийж, ЭМС-н А1562 дугаар тушаалыг хэрэгжүүлэн ажиллах

18. Коронавирусын халдварыг эрт илрүүлэх, оношлох чиглэлээр эрүүл мэндийн ажилтан бүрийг тасралтгүй сургах,

19. Холбогдох тушаал, шийдвэрийн дагуу тандалт судалгааг тогтмол хийх, тархвар судлалын асуумжийг авахдаа өмнө бүртгэгдсэн тохиолдлыг судлан тодорхой кейсүүдийг оролцуулан авдаг байх

20. Эргэлтийн үйл ажиллагааг хумих, тодорхой зохицуулалтыг хийх

21. Эмнэлгийн дэмжих хэсгийн ажилчдын /гал тогоо, ариутгал, угаалга, техникийн хэсэг, сантехникийн хэсэг, захиргаа, аж ахуйн/ халдвар хамгааллын дэглэм, хамгаалах хувцас хэрэгслийн хэрэглээг судлан, холбогдох арга хэмжээ авах,

22. Гадаргуу халдваргүйжүүлэгч бодисыг үзлэг, эмчилгээний цэгт байршуулж тогтмол хэрэглэж хэвших,

23. Байгууллагын бүх хэсэгт тодорхой хуваарийн дагуу халдваргүйтгэл хийж хэвших,

24. Эмнэлгийн тусламж үйлчилгээнээс үүсч буй хог хаягдлыг ангилан хадгалах заавар, журмын дагуу төрөлжүүлэн цуглуулж түр хадгалан, устгалын байгууллагад хүлээлгэн өгч бүртгэл тэмдэглэл тогтмол хөтлөх

25. Эмнэлгийн ажилтан, үйлчлүүлэгчдэд зориулсан ариун цэврийн өрөөний эмх цэгц, цэвэрлэгээ, халдваргүйтгэлд анхаарч, гар угаах нөхцөл бололцоог бүрэн бүрдүүлэх.

26. Байгууллага бүр аюултай хог хаягдлын аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулан гарган баталж мөрдөн ажиллах.

27. Мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн зөвлөмж, шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

28. Байгууллага бүр өөрийн QR кодыг хэвлэн байршуулж, үйлчлүүлж буй иргэд бүрээр уншуулж оруулан үйлчлэх.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт, хадгалалт, хамгаалалтын чиглэлээр:

29. Эмчилгээ үйлчилгээнд хэрэглэж буй эм, эмнэлгийн хэрэгслийн хугацаа, хадгалалтын горим, хэрэглээнд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авах.

30. Коронавирусын халдварын дэгдэлтийн үед хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх.

31. Эм, эмнэлгийн хэрэгсэл хадгалж буй өрөө бүрт өрөөний чийглэг болон дулаан хэмжигчийг байрлуулж, хадгалалтын нөхцөлийг тогтмол хянаж бүртгэх, тасалгааны хэм, чийглэгийг стандартын шаардлагад нийцүүлэх.

32. Найруулан бэлтгэсэн болон жижиглэн савалсан уусмалын шошго дээр бэлдмэлийн нэр, тун, хэмжээ, үйлдвэрлэгч, цуврал, үйлдвэрлэсэн болон найруулсан он, сар, өдөр, хэрэглэх хүчинтэй хугацаа зэрэг мэдээллийг бүрэн тусгах, хаяг шошгын зөрчилтэй бүтээгдэхүүнийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэхгүй байх.

33. Хүүхдийн эмчилгээнд хэрэглэх тариггын эмийг задалсан даруйд хэрэглэх, татан авахдаа эмийн хэлбэр, хэмжээг зөв сонгох.

34. Хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг эмнэлгийн бүх ажилтан, албан хаагчийн тоо, хэрэглээтэй холбон бодитойгоор тооцож гаргах, нөөцийг бүрдүүлэх.

35. Хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, эм, эмнэлгийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хадгалалтын горимд хяналт тавьж, зааврын дагуу эмх цэгцтэй төрөлжүүлэн ангилож хадгалах, багцалж бэлтгэх.

36. Хувийн хамгаалах хувцас хэрэгслийг хэн, хаана, хэзээ өмсөхийг тодорхой болгож, зааварчилга гаргасан байх.

37. Хамгаалах хувцас, хэрэгслийг эмнэлгийн ажилтан бүрт хүрэлцэхүйц хэмжээгээр олгох, хүлээлгэн өгсөн тухай бүртгэлийг олгосон хугацаа, нэр төрөл, тоо ширхэгээр бүртгэж, гарын үсгээр баталгаажуулах, хэрэглээнд хяналт тавих.

38. Улсын бүртгэлд бүртгэгдсэн, тухайн онд хэрэглэх химийн бодисын жагсаалтаар хэрэглэхийг зөвшөөрөгдсөн бодисыг заавар, журмын дагуу хэрэглэж, түүнд тавих дотоодын хяналтыг сайжруулах.

Мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиглэлээр:

39. Коронавируст (КОВИД-19) халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах чиглэлээр мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, ухуулах хуудас зэргийг бэлтгэн иргэдэд байнгын давтамжаар хүргэх.

40. Эрүүл мэндийн байгууллагад иргэд хоорондын зай барих тэмдэг тэмдэглэгээг байршуулж, халдвар хамгааллын дэглэм барин үйлчлүүлэх заавар зөвлөмжийг хадсан байх.

Молекул, биологийн лаборатори байгуулах чиглэлээр:

41. Төвийн 6 дүүргийн ЭМТ-үүд Молекул, биологийн лаборатори байгуулах өрөө тасалгааг бэлтгэж, стандартын шаардлагад нийцүүлэн засвар үйлчилгээг хийн бэлэн болгох.

42. Тус лабораторид ажиллах хүний нөөцийг сургаж дадлагажуулах.

43. Шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулж, ажиллагааг шалган бэлтгэх.

Албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, үр дүн, тайланг 01 дүгээр сарын 12-ны өдөр үүрэг чиглэл тус бүрээр Эмнэлгийн тусламжийн хэлтэст илрүүлэхийг мэдэгдэж байна

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР